

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

### ХУУЛЬ ЗҮЙН ТУСЛАЛЦААНЫ ТУХАЙ

/Шинэчилсэн найруулга/

2018 оны ..дугаар  
сарын ..-ны өдөр

Улаанбаатар хот

### НЭГДҮГЭЭР БҮЛЭГ НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

#### 1 дүгээр зүйл.Хуулийн зорилт

1.1.Энэ хуулийн зорилт нь Монгол Улсын хууль, олон улсын гэрээнд заасан эрх, эрх чөлөө, хууль ёсны ашиг сонирхол нь зөрчигдсөн иргэний хууль зүйн туслалцаа авах эрхийг хангах, төрөөс хууль зүйн туслалцааг үнэ төлбөргүй үзүүлэх үндэслэл, журам, тогтолцоо, зохион байгуулалт, эрх зүйн үндсийг тогтооход оршино.

#### 2 дугаар зүйл.Хууль зүйн туслалцааны хууль тогтоомж

2.1.Хууль зүйн туслалцааны хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль<sup>1</sup>, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль<sup>2</sup>, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай<sup>3</sup>, Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай<sup>4</sup>, энэ хууль, эдгээр хуультай нийцүүлэн гаргасан хууль тогтоомжоос бүрдэнэ.

2.2.Монгол Улсын олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө.

#### 3 дугаар зүйл.Хуулийн үйлчлэх хүрээ

3.1.Иргэнд хууль зүйн туслалцааг үнэ төлбөргүй үзүүлэхтэй холбоотой харилцааг энэ хуулиар зохицуулна.

3.2.Энэ хууль өмгөөлөгчийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэхтэй холбоотой харилцаанд хамаарахгүй.

---

<sup>1</sup> Монгол Улсын Үндсэн хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 1992 оны 1 дугаарт нийтлэгдсэн.

<sup>2</sup> Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2017 оны 23 дугаарт нийтлэгдсэн.

<sup>3</sup> Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2002 оны 08 дугаарт нийтлэгдсэн.

<sup>4</sup> Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2016 оны 09 дугаарт нийтлэгдсэн.

#### **4 дүгээр зүйл.Хуулийн нэр томъёоны тодорхойлолт**

4.1.Энэ хуульд хэрэглэсэн дараахь нэр томъёог доор дурдсан утгаар ойлгоно:

4.1.1.“хууль зүйн туслалцааг үнэ төлбөргүй үзүүлэх” /цаашид “хууль зүйн туслалцаа” гэх/ гэж энэ хуулийн 7 дугаар зүйлд заасан үндэслэлийн дагуу хүний эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах зорилгоор хууль зүйн зөвлөгөө өгөх, өмгөөллийн үйлчилгээ үзүүлэх, эрх зүйн сургалт, сурталчилгаа хийхийг;

4.1.2.“улсын өмгөөлөгч” гэж энэ хуульд заасны дагуу хууль зүйн туслалцаа үзүүлэх үндсэн үүрэг бүхий, бүрэн эрхээ хэрэгжүүлсний төлөө төрөөс цалин хөлс авч, ажиллах нөхцөл, баталгаагаар хангагдан ажиллаж байгаа, өмгөөллийн үйл ажиллагаа эрхлэх эрхтэй, Хууль зүйн туслалцааны төвийн хуульчийг;

#### **5 дугаар зүйл.Хууль зүйн туслалцааны зарчим**

5.1.Хууль зүйн туслалцаа үзүүлэхдээ хуульчийн мэргэжлийн үйл ажиллагааны зарчмаас гадна дараахь зарчмыг баримтална:

- 5.1.1.хүний эрх, эрх чөлөөг хүндэтгэх;
- 5.1.2.шуурхай, бүрэн, тууштай хамгаалах;
- 5.1.3.нууцыг хадгалах;
- 5.1.4.хараат бус байх;
- 5.1.5.чанартай, үр дүнтэй, хүрэлцээтэй байх.

### **ХОЁРДУГААР БҮЛЭГ ХУУЛЬ ЗҮЙН ТУСЛАЛЦАА**

#### **6 дугаар зүйл.Хууль зүйн туслалцааны төрөл**

6.1.Хууль зүйн туслалцаа нь дараахь төрөлтэй байна:

- 6.1.1.хууль зүйн зөвлөгөө өгөх;
- 6.1.2.өмгөөллийн үйлчилгээ үзүүлэх;
- 6.1.3.эрх зүйн мэдээлэл, сургалт, сурталчилгаа хийх.

6.2.Хууль зүйн зөвлөгөө нь дараахь хэлбэртэй байна:

6.2.1.хууль зүйн асуудлаар амаар, бичгээр болон цахимаар зөвлөгөө, мэдээлэл өгөх;

6.2.2.хууль зүйн ач холбогдол бүхий баримт бичгийн эх боловсруулах, хянах.

6.3.Өмгөөллийн үйлчилгээ нь дараахь хэлбэртэй байна:

6.3.1.энэ хуульд заасан гэмт хэргийн хохирогч болон сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах зорилгоор эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд өмгөөлөгчөөр оролцох;

6.3.2.энэ хуульд заасан иргэн, захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд өмгөөлөгчөөр оролцох.

6.4.Энэ хуулийн 6.1.3-т заасан туслалцааг хуульд харшлахгүй арга, хэлбэрээр явуулна.

6.5.Энэ хуулийн 6.1.3-т заасан туслалцааг үзүүлэх журмыг хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

## **7 дугаар зүйл.Хууль зүйн туслалцаа авах эрх бүхий хүн**

7.1.Доор дурдсан хүн /цаашид “үйлчлүүлэгч” гэх/ энэ хуульд заасан журмын дагуу үнэ төлбөргүй өмгөөллийн үйлчилгээ авах эрхтэй:

7.1.1. Эрүүгийн хуулийн 12 дугаар бүлэг /Хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг/-ийн арван найман насанд хүрээгүй хохирогч, 11.7 /гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх/, 16 дугаар бүлэг /Хүүхдийн эсрэг гэмт хэрэг/- т заасан гэмт хэргийн хохирогч;

7.1.2.төлбөрийн чадваргүй сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч;

7.1.3.хүүхдийн тэтгэлэг гаргуулах нэхэмжлэл гаргасан иргэн төлбөрийн чадваргүй бол;

7.1.4.газар өмчлөх эрх нь зөрчигдсөн иргэн төлбөрийн чадваргүй бол;

7.1.5.Хүүхэд хамгааллын тухай хуулийн 4.1.1-д заасан эрсдэлт нөхцөлд байгаа хүүхэд.

7.2.Ахмад настан, хөдөлмөрийн чадвараа бүрэн алдсан хүн, өрх толгойлсон олон хүүхэдтэй эцэг/эх энэ хуулийн 7.1.3, 7.1.4-т заасан хэрэг маргаанд хууль зүйн туслалцаа авч болно.

7.3.Энэ хуулийн 7.2-т заасан ахмад настан, хөдөлмөрийн чадвараа бүрэн алдсан хүн, өрх толгойлсон олон хүүхэдтэй эцэг/эх-д хууль зүйн туслалцаа үзүүлэх журмыг хууль зүйн, санхүүгийн болон нийгмийн хамгааллын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтран батална.

7.4.Гадаадын иргэн, харьяалалгүй хүнд энэ хуулийн 7.1.1, 7.1.2-т заасны дагуу хууль зүйн туслалцаа үзүүлж болно.

7.5.Энэ хуулийн 7.4-т заасан хүнд үнэ төлбөргүй хууль зүйн туслалцаа үзүүлэх журмыг хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

7.6.Хууль зүйн туслалцааны төв /цаашид “Төв” гэх/ нь Монгол Улсын иргэн, гадаадын иргэн, харьяалалгүй хүнд хууль зүйн зөвлөгөөг үнэ төлбөргүй үзүүлж болно.

## **8 дугаар зүйл.Үйлчлүүлэгчийн төлбөрийн чадваргүй байдлыг тодорхойлох**

8.1.Төлбөрийн чадваргүй хүнийг дараахь байдлаар тодорхойлно:

8.1.1.Үндэсний статистикийн хороо, нийгмийн халамжийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хамтран баталсан аргачлалын дагуу өрхийн мэдээллийн нэгдсэн санд орсон, амьжиргааны түвшин нь тухайн үеийн ядуурлын шугамаас доогуур өрхийн гишүүн бол;

8.1.2.энэ хуулийн 8.1.1-д заасан нэгдсэн санд бүртгэлгүй боловч ядуурлын шугамаас доогуур орлоготой болохоо өөрөө тодорхойлсон хүний тайлбар болон нотлох баримтад үндэслэн.

8.2.Улсын өмгөөлөгч нь хууль зүйн туслалцаа авахыг хүссэн үйлчлүүлэгчид төлбөрийн чадваргүй болохоо худал тодорхойлсон тохиолдолд хүлээлгэх хариуцлагыг урьдчилан бичгээр сануулна.

8.3.Энэ хуулийн 8.1-д заасан үйлчлүүлэгчийн төлбөрийн чадваргүй болохоо тодорхойлох өргөдлийн загварыг Төвийн захирал батална.

8.4.Төвийн ажлын алба, ахлах улсын өмгөөлөгч нь үйлчлүүлэгчийн төлбөрийн чадваргүй байдал, эсхүл энэ хуульд заасан хууль зүйн туслалцаа авах эрх бүхий хүнд хамаарах талаарх өргөдлийн мэдээллийг шалгах зорилгоор холбогдох байгууллагын мэдээллийн санг ашиглах, холбогдох албан тушаалтнаас лавлагаа, мэдээлэл авах эрхтэй бөгөөд байгууллага, албан тушаалтан нь лавлагаа, мэдээллийг даруй, үнэ төлбөргүй гаргаж өгөх үүрэгтэй.

8.5.Улсын өмгөөлөгч үйлчлүүлэгчийн өмгөөллийн үйлчилгээ авах эрхтэй хүнд хамаарах эсэхэд эргэлзээ төрвөл өргөдөлд заасан нөхцөлийг шалгаж, энэ хуульд заасан шаардлага хангаагүй бол хууль зүйн туслалцаа үзүүлэхээс татгалзах шийдвэрийг бичгээр гаргаж, хувийг үйлчлүүлэгчид өгнө.

8.6.Энэ хуулийн 8.5-д заасан хууль зүйн туслалцаа үзүүлэхээс татгалзсан шийдвэр гаргахтай холбоотой нарийвчилсан харилцааг Төвийн дүрмээр зохицуулна.

8.7.Төв нь энэ хуулийн 8.1.1-д заасан өрхийн мэдээллийн санг ашиглах эрхтэй байна.

## **9 дүгээр зүйл. Үйлчлүүлэгчийн өмгөөллийн үйлчилгээ авахад бүрдүүлэх баримт бичиг**

9.1. Энэ хуулийн 7.1-д заасан шаардлагыг хангасан хүн өмгөөллийн үйлчилгээ авах бол өргөдөл болон доорх баримт бичгийг бүрдүүлж Төвийн улсын өмгөөлөгчид хандана:

9.1.1. энэ хуулийн 8.2-т заасан төлбөрийн чадваргүй иргэний хувьд төлбөрийн чадваргүй байдлыг тогтоосон эрх бүхий этгээдийн тодорхойлолт;

9.1.2. энэ хуулийн 7.2, 7.3-т заасан хүний хувьд нотлох баримт бичиг;

9.1.3. хууль тогтоомж болон Төвийн дүрэмд заасан бусад.

9.2. Улсын өмгөөлөгч нь улсын бүртгэлийн болон төрөлжсөн мэдээллийн санд байгаа мэдээллийг өмгөөллийн үйлчилгээ авахыг хүссэн хүнээс шаардахгүй.

9.3. Улсын өмгөөлөгчөөс бусад өмгөөлөгч төлбөрийн чадваргүй этгээдэд хууль зүйн туслалцааг үнэ төлбөргүй үзүүлэхдээ энэ хуулийн холбогдох журмыг баримтална.

## **10 дугаар зүйл. Үйлчлүүлэгчийн эрх, үүрэг**

10.1. Үйлчлүүлэгч нь дараахь эрх эдэлнэ:

10.1.1. хууль зүйн туслалцааг үнэ төлбөргүй авах;

10.1.2. улсын өмгөөлөгчийн хууль зүйн туслалцаа үзүүлэхээс татгалзсан шийдвэрийн талаар гарсан маргааныг Төвд, өмгөөллийн үйлчилгээний талаар холбогдох эрх бүхий байгууллагад, Төвийн шийдвэр, үйл ажиллагааны талаар хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад тус тус гомдол гаргаж, шийдвэрлүүлэх бөгөөд шийдвэрийг эс зөвшөөрвөл гомдлоо шүүхэд гаргах;

10.1.3. хуульд заасан бусад.

10.2. Үйлчлүүлэгч нь төлбөрийн чадваргүй болохоо үнэн зөв тодорхойлох үүрэгтэй.

10.3. Үйлчлүүлэгч нь энэ хуулийн 7 дугаар зүйлд заасан хууль зүйн туслалцаа авах эрх бүхий хүн болохоо худал тодорхойлсон, эрх бүхий албан тушаалтан хуурамч тодорхойлолт, шийдвэр гаргасан бол гэм буруутай этгээдээр гарсан зардлыг нөхөн төлүүлнэ.

## **ГУРАВДУГААР БҮЛЭГ ХУУЛЬ ЗҮЙН ТУСЛАЛЦАА ҮЗҮҮЛЭХ ТОГТОЛЦОО**

**11 дүгээр зүйл. Төвийн удирдлага, зохион байгуулалт**

11.1.Төв нь энэ хуульд заасан хууль зүйн туслалцааг үнэ төлбөргүй үзүүлэх ажлыг зохион байгуулах чиг үүрэг бүхий төрийн байгууллага байна.

11.2.Төв нь хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын харьяанд байна.

11.3.Хууль зүйн туслалцааны төвийн тогтолцоо нь Төв, түүний ажлын алба, салбараас бүрдэнэ.

11.4.Төв нь чиг үүргээ хэрэгжүүлэхэд шаардлагатай хууль зүйн зөвлөгөө өгөх, эрх зүйн сургалт сурталчилгаа, явуулах болон судалгааны нэгжтэй байж болно.

11.5.Төвийн ажлын алба нь хууль зүйн туслалцаа үзүүлэх үйл ажиллагааг удирдан зохион байгуулна.

11.6.Төвийн салбар нь энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан хууль зүйн туслалцааг энэ хуульд заасны дагуу үзүүлнэ.

11.7.Төвийн салбарт улсын өмгөөлөгч, өмгөөлөгчийн туслах ажиллана.

11.8.Улсын өмгөөлөгч нь ажил үүргийн болон хуульчийн мэргэжлийн өөрөө удирдах ёсны зарчмаар зохион байгуулагдан ажиллана.

11.9.Төв, түүний салбар нь тогтоосон журмаар үйлдсэн тамга, тэмдэг, албан бичгийн хэвлэмэл хуудас хэрэглэнэ.

11.10.Төвийн бүтэц, орон тоог хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн тогтооно.

11.11.Төв нь үйл ажиллагаагаа явуулахад туслах үүрэг бүхий өмгөөлөгчдийн холбоо, Хуульчдын холбоо, хүний эрхийн асуудал эрхэлсэн төрийн бус байгууллагын төлөөллийг оролцуулсан орон тооны бус зөвлөл байгуулж болно.

## **12 дугаар зүйл.Төвийн чиг үүрэг**

12.1.Төвийн дараахь чиг үүргийг хэрэгжүүлнэ:

12.1.1.салбарыг мэргэжил арга зүйн удирдлагаар хангах:

12.1.2.хүний нөөцийн бодлого боловсруулах, улсын өмгөөлөгч, албан хаагчийг сургаж бэлтгэх, тэдний мэдлэг боловсролыг дээшлүүлэх арга хэмжээ авах;

12.1.3.чиг үүргийн хүрээнд гадаад, дотоодын байгууллагатай хамтран ажиллах;

12.1.4.тухайн нутаг дэвсгэрт оршин суугаа хүн амын тоо, гэмт хэргийн гаралт, хууль зүйн туслалцаа үнэ төлбөргүй авах эрх бүхий хүний эзлэх хувь, улсын өмгөөлөгчийн ажлын ачаалал зэргийг харгалзан Төвийн салбарт ажиллах улсын өмгөөлөгчийн орон тоог тогтоох, Төвийн салбар байгуулах, өөрчлөн байгуулах, татан буулгах эсэх асуудлаар санал боловсруулах;

12.1.5.улсын өмгөөлөгчийг сонгон шалгаруулах ажлыг зохион байгуулах;

12.1.6.улсын өмгөөлөгчдийн нэгдсэн бүртгэл хөтлөх, үйл ажиллагааг нь уялдуулан зохицуулах;

12.1.7.улсын өмгөөлөгчийн хуульчийн үргэлжилсэн болон мэргэшүүлэх сургалтыг холбогдох байгууллагатай хамтран зохион байгуулах;

12.1.8.Төвийн салбар байгуулагдаагүй нутаг дэвсгэрт хууль зүйн туслалцаа үзүүлэх ажлыг эрх бүхий байгууллагатай хамтран зохион байгуулах;

12.1.9.нийслэлээс бусад газарт байрлах Төвийн салбарыг нүүдэллэн ажиллах үед удирдлага, зохион байгуулалтаар хангах;

12.1.10.хууль зүйн туслалцааны үйл ажиллагааг олон нийтэд сурталчлах;

12.1.11.хууль зүйн туслалцааны чанар, үр нөлөөг тооцоолох, үнэлэх үйл ажиллагаа, шалгуур үзүүлэлтийг хангах ажлыг зохион байгуулах;

12.1.12.хүний нөөц, дэд бүтэц, техник тоног төхөөрөмжөөр хангах бодлого боловсруулж, хэрэгжүүлэх;

12.1.13.Төв, түүний салбарын үйл ажиллагааны тайлан, мэдээг улсын хэмжээнд нэгтгэн гаргах, хуулийн дагуу мэдээлэх, нийтэд ил тод хүргэх;

12.1.14.хууль зүйн туслалцааны статистик мэдээг гаргах, түүнд дүн шинжилгээ хийх;

12.1.15.хууль зүйн туслалцааны хууль тогтоомж, дүрэм, журмын биелэлтийг хангах, хэрэгжилтэд хяналт тавих;

12.1.16.эрх зүйн мэдээлэл, сургалт, сурталчилгаа хийх ажлыг зохион байгуулах;

12.1.17.хууль зүйн туслалцаа үзүүлэх асуудлаар төрийн байгууллага, хуулийн этгээдийн үйл ажиллагааг уялдуулан зохицуулах;

12.1.18.иргэнд хууль зүйн туслалцаа авах арга замыг зааж өгөх, энэ талаарх мэдээллийг дамжуулж зуучилж өгөх;

12.1.19.өргөдөл, гомдлыг хүлээн авах, шийдвэрлэх.

12.2.Төвийн удирдах, гүйцэтгэх албан тушаалтан болон салбарын дарга нь төрийн захиргааны албан хаагч байна.

12.3.Энэ хуулийн 15.1.5-д заасан Төвийн дүрэмд дараахь зүйлийг тусгана:

12.3.1.Төв, түүний ажлын алба, салбарын чиг үүрэг;

12.3.2.Төвийн захирал, Төвийн салбарын ахлах улсын өмгөөлөгчийн захиргааны чиг үүрэг;

12.3.3.улсын өмгөөлөгчийг сонгон шалгаруулах ажлын зохион байгуулалт;

12.3.4.ажлын байрны нөхцөл, стандарт;

12.3.5.байгууллагын бэлгэдэл, далбаа, энгэрийн тэмдэг хэрэглэх заавар;

12.3.6.энэ хуульд заасан бусад зүйл.

### **13 дугаар зүйл.Төвийн захирлын бүрэн эрх**

13.1.Төвийн захирал нь энэ хууль болон дүрмээр олгогдсон эрх хэмжээний дотор Төвийн өдөр тутмын үйл ажиллагааг удирдан зохион байгуулна.

13.2.Төвийн захирал нь дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

13.2.1.Төвийн дүрмийг боловсронгуй болгох санал боловсруулж, шийдвэрлүүлэх;

13.2.2.Төвийн салбарын үйл ажиллагаанд хяналт тавьж, чиглэл өгөх;

13.2.3.Төвийн үйл ажиллагааг сайжруулахтай холбогдсон шаардлагатай арга хэмжээний талаарх саналаа хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнд танилцуулж, шийдвэрлүүлэх;

13.2.4.улсын өмгөөлөгчийн цалин хөлс, нэмэгдэл, нэмэгдэл хөлсний талаар санал боловсруулж, хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнд танилцуулж, шийдвэрлүүлэх;

13.2.5.хууль зүйн туслалцааны үйл ажиллагааг хэвийн явуулахтай холбоотой гэрээ байгуулах шийдвэр гаргах;



13.2.6. салбарын дарга, улсын өмгөөлөгч, өмгөөлөгчийн туслах, Төвийн Ажлын албаны болон нэгжийн дарга, ажилтныг томилох, чөлөөлөх, халах, сахилгын шийтгэл ногдуулах;

13.2.7.хувийн өмгөөлөгчийн зардал, тайлангийн загварыг батлах;

13.2.8.улсын өмгөөлөгчийн энэ хууль болон бусад хууль тогтоомжид заасан үндэслэлээр хууль зүйн туслалцаа үзүүлэхээс татгалзсан шийдвэрийг хянах, энэ талаарх гомдлыг хүлээн авч шийдвэрлэх;

13.2.9.улсын өмгөөлөгчийн тухайн нутаг дэвсгэртээ нүүдэллэн ажиллах хуваарь, удирдамжийг Төвийн салбарын саналыг харгалзан батлах;

13.2.10.үйлчлүүлэгчид үзүүлэх хууль зүйн туслалцааны чанар, үр нөлөөг тооцоолох, үнэлэх үйл ажиллагаа, шалгуур үзүүлэлтийг батлах;

13.2.11.улсын өмгөөлөгч, ажилтантай, хөдөлмөрийн гэрээ байгуулах, цуцлах, түүнд олгох урамшуулал, хөнгөлөлт, тусламж, тэтгэмжийн хэмжээг тогтоох;

13.2.12.хууль зүйн туслалцааны үйл ажиллагаанд дагаж мөрдөх дүрэм, журмыг энэ хууль, бусад хууль тогтоомжид нийцүүлэн баталж, биелэлтийг хангуулах;

13.2.13.Төвийн дотоод зохион байгуулалтын асуудлыг шийдвэрлэх;

13.2.14.хуульд заасан бусад бүрэн эрх.

#### **14 дүгээр зүйл.Хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын чиг үүрэг**

14.1.Хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хууль зүйн туслалцааны талаар дараахь чиг үүргийг хэрэгжүүлнэ:

14.1.1.Төвийг нэгдсэн удирдлагаар хангаж, хяналт тавих;

14.1.2.хууль зүйн туслалцааг үнэ төлбөргүй үзүүлэх үйл ажиллагаанд хяналт шинжилгээ, үнэлгээ хийх, боловсронгуй болгох санал боловсруулах;

14.1.3.хууль зүйн туслалцааны хууль тогтоомж, дүрэм, журмын биелэлтийг хангуулах;

14.1.4.хуульд заасан бусад чиг үүрэг.

#### **15 дугаар зүйл.Хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний бүрэн эрх**

15.1.Хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хууль зүйн туслалцааны талаар дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

15.1.1.Төвийн бүтэц, орон тоог тогтоох;

15.1.2.Төвийн захирлыг томилох, чөлөөлөх, халах;

15.1.3.Төвийн саналыг үндэслэн салбарын байршил, бүтэц, тоо, тухайн салбарт ажиллах улсын өмгөөлөгч, өмгөөлөгчийн туслахын орон тоог тогтоох, салбарыг шинээр байгуулах, өөрчлөн байгуулах, татан буулгах асуудлыг шийдвэрлэх;

15.1.4.үйлчлүүлэгчтэй болон хувийн өмгөөлөгчтэй байгуулах гэрээний загварыг батлах; хууль зүйн туслалцаа үзүүлэхээс татгалзах шийдвэрийн загварыг батлах;

15.1.5.Төвийн дүрэм, хууль зүйн туслалцаа үзүүлэх үйл ажиллагаанд дагаж мөрдөх бусад дүрэм, журмыг батлах;

15.1.6.хуульд заасан бусад бүрэн эрх.

15.2.Улсын өмгөөлөгчийн хууль зүйн туслалцаа үзүүлэх цалин хөлс нэмэгдэл, нэмэгдэл хөлсний жишгийг хууль зүйн болон санхүүгийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтран тогтооно.

## **16 дугаар зүйл.Засгийн газрын бүрэн эрх**

16.1.Засгийн газар хууль зүйн туслалцааны талаар дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

16.1.1.хууль зүйн туслалцааны талаар төрөөс баримтлах бодлогыг баталж, хэрэгжүүлэх, хяналт тавих;

16.1.2.хууль зүйн туслалцааны тухай хууль тогтоомжийн биелэлтийг хангах;

16.1.3.Төвийн удирдах болон гүйцэтгэх, албан тушаалтан, салбарын даргын албан тушаалын ангилал, зэрэглэлийг төрийн албаны төв байгууллагын саналыг үндэслэн тогтоох.

## **17 дугаар зүйл.Хууль зүйн туслалцаа үзүүлэх үйл ажиллагааг тайлагнах хэлбэр**

17.1.Төв нь санхүүгийн болон үйл ажиллагааны улирал, хагас, бүтэн жилийн тайланг батлагдсан маягтын дагуу, тогтоосон хугацаанд гаргаж, хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон холбогдох байгууллагад хүргүүлнэ.

**ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ**  
**УЛСЫН ӨМГӨӨЛӨГЧ, ТҮҮНИЙ ЧИГ ҮҮРЭГ, БАТАЛГАА, ҮЙЛ АЖИЛЛАГААНД**  
**ХОРИГЛОХ ЗҮЙЛ**

**18 дугаар зүйл.Улсын өмгөөлөгч**

18.1.Улсын өмгөөлөгч нь хууль зүйн туслалцаа үзүүлэх ажлыг хөдөлмөрийн гэрээний үндсэн дээр гүйцэтгэнэ.

**19 дүгээр зүйл.Улсын өмгөөлөгчийн чиг үүрэг**

19.1.Улсын өмгөөлөгч нь дараахь чиг үүрэгтэй:

19.1.1.хууль зүйн туслалцааг үйлчлүүлэгчид үнэ төлбөргүй үзүүлэх;

19.1.2.үйлчлүүлэгчийнхээ эрх, хууль ёсны ашиг сонирхлыг бүрэн, тууштай хамгаалах;

19.1.3.энэ хуулийн 9.1-д заасан өргөдлийг хүлээн авч, холбогдох маягт, бүртгэлийг хөтлөх;

19.1.4.хуульд заасан бусад чиг үүрэг.

19.2.Төвийн захирал болон салбарын дарга нь дотоод зохион байгуулалтын шинжтэй үйл ажиллагаанаас бусад асуудлаар улсын өмгөөлөгчийн хууль зүйн туслалцаа үзүүлэх үйл ажиллагаанд хөндлөнгөөс оролцохыг хориглоно.

**20 дугаар зүйл.Улсын өмгөөлөгчийн үйл ажиллагаанд**  
**хориглох зүйл**

20.1.Улсын өмгөөлөгчийн үйл ажиллагаанд дараахь үйлдлийг хориглоно:

20.1.1.энэ хуульд заасан үндэслэл, журмаас гадуур өмгөөллийн үйл ажиллагаа үзүүлэх;

20.1.2.хууль зүйн чиглэлээр багшлах, эрдэм шинжилгээний болон хуульчийн мэргэжлийн өөрөө удирдах ёсны байгууллагад хамаарахаас бусад ажил, албан тушаалыг хавсран эрхлэх;

20.1.3.энэ хуулийн 8.4-т заасан мэдээллийг өөр зорилгоор ашиглах.

20.2.Улсын өмгөөлөгч нь мэргэжлийн үйл ажиллагаагаа холбогдох хууль тогтоомжид заасны дагуу явуулна.

20.3.Улсын өмгөөлөгчөөр хуулиар хүлээлгэсэн үүрэгт нь үл хамаарах ажил, үүрэг гүйцэтгүүлэхийг хориглоно.

20.4.Улсын өмгөөлөгч нь нам, үйлдвэрчний эвлэлийн гишүүн байх, аливаа улс төрийн шинжтэй үйл ажиллагаанд оролцохыг хориглоно.

## **21 дүгээр зүйл.Улсын өмгөөлөгчийн ажиллах нөхцөл, баталгаа**

21.1.Улсын өмгөөлөгч нь холбогдох хуульд заасан өмгөөллийн үйлчилгээний баталгаанаас гадна дараахь баталгаагаар хангагдана:

21.1.1.хуульчийн үргэлжилсэн сургалтад хамрагдах нөхцөлөөр хангагдах;

21.1.2.өмгөөлөгчийн чиг үүргээ хэрэгжүүлэхэд шаардлагатай ажиллах нөхцөлөөр хангагдах;

21.1.3.хууль тогтоомж болон гэрээнд заасан чиг үүргээ хэрэгжүүлсний төлөө төрөөс цалин, нэмэгдэл хөлс, нэмэгдэл, шагнал урамшуулал авах;

21.1.4.жил бүр эрүүл мэндийн үзлэгт хамрагдах;

21.1.5.орон байраар хангагдахад төрөөс дэмжлэг үзүүлэх;

21.1.6.улсын өмгөөлөгч өндөр насны тэтгэвэр тогтоолгох үндэслэлээр чөлөөлөгдсөн бол үндсэн цалингийн дунджаас ажилласан хугацааг нь үндэслэн тооцож нэг удаагийн буцалтгүй тусламжийг олгох;

21.1.7.ээлжийн амралтаараа өөрийн, эсхүл эхнэр, нөхрийн төрсөн нутагт ирэх, очих замын зардлыг тухайн үед мөрдөж байгаа автомашин, төмөр замын үнэлгээгээр тооцож 2 жилд нэг удаа олгох;

21.1.8.Хөдөлмөрийн тухай хуулиар тогтоосон ээлжийн амралт эдлэх;

21.1.9.аймгийн төвд тасралтгүй ажиллаж байгаа улсын өмгөөлөгчид 6 сарын, суманд тасралтгүй ажиллаж байгаа улсын өмгөөлөгчид 12 сарын үндсэн цалинтай тэнцэх хэмжээний мөнгөн урамшлыг 5 жил тутам олгох;

21.1.7.хуульд заасан үндэслэл журмын дагуу хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа явуулсны төлөө хариуцлага хүлээхгүй байх.

21.1.8.улсын өмгөөлөгчөөр ажиллах хугацаанд Хуульчийн эрх зүйн байдлын тухай хууль, Өмгөөллийн тухай хуульд заасан Хуульчдын болон Өмгөөлөгчдийн холбооны гишүүний татвар, хураамж, өмгөөлөгчийн хариуцлагын даатгалын хураамж, хуульчийн үргэлжилсэн сургалтын төлбөрөөс чөлөөлөгдөх;

21.2.Энэ хуулийн 21.1.6-д заасан нэг удаагийн буцалтгүй тусламжийн дээд хэмжээ нь 36 сарын үндсэн цалингийн дунджаас хэтрэхгүй байх бөгөөд нэг удаагийн буцалтгүй тусламж тооцох цалингийн дундаж хэмжээ болон түүнийг олгох шалгуур нөхцөлийг тодорхойлсон журам болон 21.9-д заасан мөнгөн

урамшил олгох журмыг төрийн албаны төв байгууллагын саналыг үндэслэн Засгийн газар тогтооно.

21.3.Энэ хуулийн 21.1, 21.2-т заасан зардлыг төр хариуцна.

21.4.Улсын өмгөөлөгчөөр гурван жил тасралтгүй ажилласан албан хаагчийг цэргийн албыг дүйцүүлэн хаасанд тооцно.

## **ТАВДУГААР БҮЛЭГ ХУВИЙН ӨМГӨӨЛӨГЧИЙГ ОРОЛЦУУЛАХ**

### **22 дугаар зүйл.Хувийн өмгөөлөгчийг оролцуулах нөхцөл**

22.1.Хувийн өмгөөлөгчийг дараахь нөхцөлд хууль зүйн туслалцаа авах эрх бүхий хүний өмгөөлөгчөөр ажиллуулна:

22.1.1.улсын өмгөөлөгч нь үйлчлүүлэгчтэй ашиг сонирхлын зөрчилтэй;

22.1.2.нэг хэрэгт харилцан эсрэг сонирхолтой хоёр ба түүнээс дээш үйлчлүүлэгч хууль зүйн туслалцаа авах өргөдөл гаргасан;

22.1.3.үйлчлүүлэгч нь холбогдох хуульд заасан үндэслэл, журмын дагуу улсын өмгөөлөгчөөс татгалзсан;

22.1.4.тухайн нутаг дэвсгэрт Төвийн салбар байхгүй, улсын өмгөөлөгч байхгүй бол.

22.2.Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 45.1.11-д заасан Хуульчдын холбооны чиг үүргийг хувийн өмгөөлөгчийн хууль зүйн туслалцааг үнэ төлбөргүй үзүүлэх үйл ажиллагаатай уялдуулан зохицуулна.

22.3.Төв нь хувийн өмгөөлөгчийг ажиллуулахдаа үнэ төлбөргүй өмгөөллийн үйлчилгээг үзүүлэх хувийн өмгөөлөгчдөөс, байхгүй тохиолдолд үйлчлүүлэгч нь тухайн нутаг дэвсгэрт өмгөөллийн үйлчилгээ явуулж байгаа өмгөөлөгчид хүсэлт гаргаснаар оролцуулна.

22.4.Төвийн салбар нь хувийн өмгөөлөгчийг ажиллуулах нөхцөл бий болсон тохиолдолд хууль зүйн туслалцаа үзүүлэх гэрээ байгуулна.

22.5.Хувийн өмгөөлөгчийн өмгөөллийн үйлчилгээний ажлын хөлсний жишгийг хууль зүйн болон санхүүгийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтран тогтооно.

22.6.Энэ хуулийн 22.5-д заасан жишгийг тогтоохдоо улсын өмгөөлөгчийн цалин хөлсний жишгээр тогтооно.

## **23 дугаар зүйл.Төлбөрийг гүйцэтгэх, түүний санхүүжилтийн хэлбэр**

23.1.Энэ хуулийн 22 дугаар зүйлд заасны дагуу гэрээгээр өмгөөллийн үйлчилгээ үзүүлсэн хувийн өмгөөлөгч нь холбогдох стандартын дагуу хэргийн материалыг бүрдүүлж, өмгөөллийн үйлчилгээний тайланг батлагдсан маягтын дагуу гаргаж, тогтоосон хугацаанд тухайн Төвийн салбарт ирүүлнэ.

23.2.Энэ хуулийн 22.1-д заасан материалтай тухайн Төвийн салбарыг ахлах улсын өмгөөлөгч танилцаж, гэрээний гүйцэтгэлийг дүгнэх бөгөөд энэ нь төлбөр гүйцэтгэх үндэслэл болно.

23.3.Хувийн өмгөөлөгчийн өмгөөллийн ажлын хөлс энэ хуулийн 24 дүгээр зүйлд заасан эх үүсвэрээс санхүүжүүлнэ.

## **ЗУРГААДУГААР БҮЛЭГ САНХҮҮЖИЛТ**

### **24 дүгээр зүйл.Санхүүжилтийн эх үүсвэр**

24.1.Хууль зүйн туслалцаа үзүүлэх үйл ажиллагааг улсын төсвөөс санхүүжүүлэх бөгөөд энэхүү төсөв нь хууль зүйн туслалцааны үйл ажиллагаагаа шуурхай, тасралтгүй, үр дүнтэй явуулах шаардлагыг хангасан байна.

24.2.Төв нь хууль зүйн туслалцаа үзүүлэх үйл ажиллагаанд зориулан хуулиар хориглоогүй эх үүсвэрээс өгсөн буцалтгүй тусламж, хандив хүлээн авч болно.

## **ДОЛООДУГААР БҮЛЭГ**

### **ХУУЛЬ ЗҮЙН ТУСЛАЛЦАА ҮЗҮҮЛЭХЭД БУСАД БАЙГУУЛЛАГЫН ОРОЛЦОО**

### **25 дугаар зүйл. Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг даргын оролцоо**

25.1.Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга хууль зүйн туслалцаа үзүүлэх үйл ажиллагаанд дараахь байдлаар дэмжлэг үзүүлнэ:

25.1.1.Төвийн салбарыг стандартын шаардлага хангасан ажлын байр, техник, тоног төхөөрөмж, тээврийн хэрэгслээр хангах;

25.1.2.хууль зүйн туслалцаа үзүүлэх чиг үүргийг хэрэгжүүлэх нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор тухайн нутаг дэвсгэрт ажиллахаар томилогдсон улсын өмгөөлөгчийг орон байраар хангахад дэмжлэг үзүүлэх.

25.2.Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг дарга нь иргэдийн эрх, эрх чөлөө, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах чиг үүргийг хэрэгжүүлэх нөхцөлийг

бүрдүүлэх зорилгоор Төвийн салбарын ажилчдыг орон байр, хүнс, тээвэр, холбооны хэрэгслээр хангах, томилогдсон алба хаагч, түүний гэр бүлийн гишүүдэд дэмжлэг үзүүлэх арга хэмжээнд шаардагдах зардлыг орон нутгийн төсөвт тусган санхүүжүүлж болно.

## **26 дугаар зүйл.Монголын Хуульчдын холбооны оролцоо**

26.1.Монголын хуульчдын холбоо нь хууль зүйн туслалцаа үзүүлэх үйл ажиллагаанд дараахь байдлаар оролцож, хамтран ажиллана:

26.1.1.улсын өмгөөлөгчийн хуульчийн үргэлжилсэн сургалт болон мэргэшүүлэх сургалт зохион байгуулахад хөнгөлөлт, дэмжлэг үзүүлж, хамтран ажиллах.

26.1.2.Хууль зүйн туслалцааны төвийн үйл ажиллагааг бэхжүүлэх, хууль зүйн туслалцааны хүртээмжийг нэмэгдүүлэх чиглэлээр Хууль зүйн туслалцааны төвтэй хамтран ажиллах.

## **27 дугаар зүйл.Өмгөөлөгчдийн холбооны оролцоо**

27.1.Өмгөөлөгчдийн холбоо нь хууль зүйн туслалцаа үзүүлэх үйл ажиллагаанд дараахь байдлаар оролцож, хамтран ажиллана:

27.1.1.Өмгөөлөгчдийн холбооноос өмгөөлөгчийн үнэ төлбөргүй хууль зүйн туслалцаа үзүүлэх үйл ажиллагааг энэ хуульд заасны дагуу Төвийн үйл ажиллагаатай уялдуулан зохицуулна.

27.1.2.Төвийн улсын өмгөөлөгчид үзүүлэх хөнгөлөлт, урамшууллын тогтолцоог бий болгох.

27.2.Энэ хуулийн 27.1.1-д заасан үйл ажиллагааг хэрэгжүүлэх журмыг Төвийн захирал, Өмгөөлөгчдийн холбооны ерөнхийлөгчтэй хамтран батална.

## **28 дугаар зүйл.Хууль зүйн туслалцааны мэдээллийн сан**

28.1.Төв нь хууль зүйн туслалцааны мэдээллийн сантай байна.

28.2.Хууль зүйн туслалцааны мэдээллийн санг бүрдүүлэх, ашиглах, хамгаалах, мэдээлэл солилцох журмыг хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

28.3.Хууль зүйн туслалцааны мэдээллийн санд хууль зүйн туслалцаа үзүүлж байгаа байгууллагууд мэдээллээ оруулах үүрэгтэй.

28.4.Хууль зүйн туслалцааны мэдээллийн санг бүрдүүлэх, ашиглах, хадгалах, хамгаалах, мэдээлэл өгөх журмыг хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

28.5.Өмгөөлөгчийн өмгөөллийн үйл ажиллагааг тогтмол эрхлэх нутаг дэвсгэр, ажлын байрны хаяг, утас, цахим шуудангийн хаягийг Өмгөөлөгчдийн холбооноос Төвд тухай бүр мэдэгдэнэ.

28.6.Улсын өмгөөлөгчөөс бусад өмгөөлөгч өмгөөллийн үйлчилгээг үнэ төлбөргүй үзүүлэх үүргээ дүйцүүлэн биелүүлж болох бөгөөд төлбөрийн хэмжээг улсын өмгөөлөгчийн цалин хөлсний жишгээр тогтооно.

28.7.Энэ хуулийн 28.6-д заасан орлогыг хууль зүйн туслалцаа үзүүлэхэд зарцуулна.

## **НАЙМДУГААР БҮЛЭГ БУСАД ЗҮЙЛ**

### **29 дүгээр зүйл.Хууль зөрчигчид хүлээлгэх хариуцлага**

29.1.Энэ хуулийг зөрчсөн албан тушаалтны үйлдэл нь гэмт хэргийн шинжгүй бол Төрийн албаны тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

29.2.Энэ хуулийг зөрчсөн хүн, хуулийн этгээдэд Эрүүгийн хууль, эсхүл Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

29.3.Энэ хуулийн 20 дугаар зүйлд заасан шаардлага хангаагүй, хориглосон үйл ажиллагаа явуулсан улсын өмгөөлөгчтэй байгуулсан хөдөлмөрийн гэрээг цуцалж, хуульчийн мэргэжлийн үйл ажиллагааны зөрчилтэй холбогдох аливаа үйлдэл, эс үйлдэхүйг холбогдох байгууллагад мэдэгдэнэ.

### **30 дугаар зүйл.Хууль хүчин төгөлдөр болох**

30.1.Энэ хуулийг 2019 оны ... дүгээр сарын ..-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.